

**МОНГОЛ УЛСЫН  
ТҮҮХ**

**2010**

ХУВИЛБАР А

1. Хэдий үед Монгол орон эх газрын, эрс тэс, хуурай сэрүүн уур амьсгалтай болсон бэ? (2 оноо)  
А. 100 000 жилийн тэртээгээс В. 40 000 жилийн тэртээгээс  
С. 15 000 жилийн тэртээгээс D. 8 000 жилийн тэртээгээс  
E. 3 000 жилийн тэртээгээс
2. Дараах соёлт давхрагуудын алинаас нь авсан дээжний шинжилгээ 730 000 жилийн өмнө Монгол нутагт хүн амьдарч байсныг гэрчилдэг вэ? (2 оноо)  
А. Цагаан агуйн соёлт давхрага В. Цахиуртын хөндийн соёлт давхрага  
С. Мойлтын амны соёлт давхрага D. Ярх уулын соёлт давхрага  
E. Рашаан хадны соёлт давхрага
3. Дараах дурсгалуудын аль нь хүрэл зэвсгийн үед анх Монгол нутагт үүсч, Ази-Европын хээр талд тархсан бэ? (2 оноо)  
А. Буган хөшөө В. Дөрвөлжин булш  
С. Хиргисүүр D. Хүн чулуу  
E. Хадны сийлмэл зураг
4. Хэдий үед чулуун иртэй ясан хутга, ясан зэв, шөвөг, ясан зүүлт, бугуйвч зэргийг өргөн хэрэглэх болсон бэ? (2 оноо)  
А. Дунд палеолитын үед В. Дээд палеолитын үед  
С. Мезолитын үед D. Неолитын үед  
E. Энеолитын үед
5. Аль нь Хүннү нарын уугуул нутаг вэ? (2 оноо)  
А. Цагаан хэрмээс Байгаль нуур, Солонгосын хойгоос Ил тарвагатай хүртэлх нутагт оршиж байв  
В. Хянганы нуруугаар төвлөрч, Шар мөрнөөс Эргүнэ мөрөн, Дорнодын талаас Ляохэ голын эх хүрч байв  
С. Хангайн нуруугаар төвлөрөн Их элсэн говиос Байгаль нуур, Хянганы нуруунаас Алтайн нуруу хүрч байв  
D. Ордосоос Байгаль нуур өнгөрч, Алтайн нуруунаас Дорнодын тал хүрч байв  
E. Их элсэн говиос Байгаль нуур, Солонгосын хойгоос Хар сайр хүртэлх уудам нутагт оршин тогтнож байв
6. Модунь шаньюй улсынхаа аль хэсгийг өөрөө захирдаг байсан бэ? (2 оноо)  
А. Зүүн гараа В. Баруун гараа С. Төвийн хэсгээ  
D. Түмтээ E. Мянгатаа
7. Аль нь чулуу, төмөр боловсруулах талаараа эртний улсуудын дунд тэргүүлж байсан бэ? (2 оноо)  
А. Хүннү В. Сяньби С. Нирун D. Түрэг E. Уйгур
8. Од гаригийн хөдөлгөөний мөчлөгт тулгуурлаж 12 жилийн цаг тоолол бий болгож хожмын жарны тооллын үндсийг тавьсан улс аль нь вэ? (2 оноо)  
А. Хүннү В. Сяньби С. Нирун D. Түрэг E. Уйгур
9. Түрэгүүд нас барагсдаа хэрхэн оршуулдаг байсан бэ? (2 оноо)  
А. Шарилыг нь чандарлаад, тахилын сүм барьж, хөрөг дүрсийг нь залж, дайнд оролцож явсан тухай нь тэмдэглэдэг  
В. Шарилыг нь занданшуулж, тахилын сүм барьж, хөргийг нь зурж, гавъяа зүтгэлийг нь тэмдэглэдэг  
С. Шарилыг нь хагааж, тахилын сүм барьж, хөргийг нь залж, дайны олзноос дагалдуулдаг  
D. Шарилыг нь чулуун хашлагатай бунханд, ихэвчлэн ил тавьж, мал дагалдуулдаг  
E. Шарилыг нь шороон хашлагатай бунханд, эсгийнд ороож, морь дагалдуулдаг
10. Эргүнэ-гүнд анх очсон овгууд аль нь вэ? (2 оноо)  
А. Урианхай, Хиян В. Хонгирад, Элжигэн С. Баяуд, Нукуз  
D. Хиян, Нукуз E. Урианхай, Хонгирад
11. Дарлигин Монголчууд хэзээ, хэний удирдлагаар эх нутагтаа эргэн ирж, хаана нутагласан бэ? (2 оноо)  
А. VIII зууны эхээр, Гоо маралаар, Онон голд  
В. VIII зууны дундуур, Есүхэй баатараар Хэрлэн голд  
С. VIII зууны сүүлийн хагаст, Бөртэ-чоноор, Бурхан халдунд  
D. IX зууны эхээр, Алан-гуагаар, Буур хээрт  
E. IX зууны дундуур, Добу мэргэнээр, Туул голд
12. Хабул хан амьд ахуйдаа өөрийн залгамжлагчаар хэнийг гэрээсэлсэн бэ? (2 оноо)  
А. Өөрийн хүү Хотулаг В. Тайчуудын Амбагайг С. Хүү Охинбархагыгаа  
D. Хүү Бартанбаатарыг E. Ач хүү Есүхэй баатарыг

13. Тэмүжинг хэзээ, хаана Хамаг Монгол улсын хаанаар өргөмжилсөн бэ? (2 оноо)  
 А. 1162 онд Онон мөрний эхэнд В. 1189 онд Хэрлэний Хөдөө аралд  
 С. 1206 онд Орхоны савд D. 1189 онд Хар зүрхэний Хөх нуурт  
 E. 1189 онд Балжун нуурт
14. Их Монгол улсын төрийн гол шүтлэг аль нь вэ? (2 оноо)  
 А. Бөө мөргөл В. Шарын шашин С. Улааны шашин  
 D. Христосын шашин E. Бүгдийг тэгш үзэж байсан
15. Чингис хаан улсаа хэдэн мянгатад хуваасан бэ? (2 оноо)  
 А. 90 мянгатад В. 91 мянгатад С. 95 мянгатад  
 D. 100 мянгатад E. 108 мянгатад
16. Чингис хааны дөрвөн нохос буюу жанжид хэн хэн бэ? (2 оноо)  
 А. Зэв, Зэлмэ, Сүбээдэй, Хубилай В. Зэв, Сүбээдэй, Хубилай, Чулуун  
 С. Зэлмэ, Сүбээдэй, Мухулай, Чулуун D. Мухулай, Чулуун, Зэв, Сүбээдэй  
 E. Зэв, Боорчи, Зэлмэ, Чулуун
17. Дараах он цаг болон үйл явдлын хамаарлыг тогтооно уу. (2 оноо)  
 1. 1211 он а. Чингис хаан Тангуд руу хөдөлжээ.  
 2. 1228 оны 9 сар в. Чингис хаан эцэг өвгөдийн гэрээсийг биелүүлж олон жилийн “өшил өшин хясал хясахаар” их цэргийн хүчээр Алтан улсад довтлон оров.  
 3. 1225 оны намар с. Хүчирхэг Хорезм улс монголчуудад эзлэгдэв.  
 4. 1217 оны 8 сар d. Өгэдэйг хаан өргөмжлөх Их хуралдайг Хэрлэнгийн хөдөө аралд зарлан хуралдуулжээ.  
 5. 1224 он e. Чингис хаан үлдсэн газар нутгийг эзлэх үүргийг Мухулайд даалгаж, нутагтаа буцаж ирэв.  
 А. 1а, 2d, 3в, 4е, 5с В. 1в, 2а, 3d, 4е, 5с С. 1с, 2d, 3а, 4в, 5е  
 D. 1в, 2d, 3а, 4е, 5с E. 1е, 2в, 3с, 4d, 5е
18. Цэгийн оронд дараах өгөгдлүүдээс тохирохыг нь сонгоно уу. (2 оноо)  
 Монгол бичгийн одоогоор олддоод байгаа хамгийн анхны дурсгал нь ..... юм.  
 А. Монголын нууц товчоо В. Алтан товч С. Судрын чуулган  
 D. Их засаг хууль E. Чингисийн чулууны бичиг
19. Хэн Төвдийн лам Пагваг улсын багшаар өргөмжилсөн бэ? (2 оноо)  
 А. Мөнх хаан В. Хубилай хаан С. Алтан хаан  
 D. Түмэн засагт хаан E. Автай сайн хаан
20. Бурхны шашны хөлгөн судар 108 боть Ганжуурыг 33 эрдэмтнээр орчуулуулж, алтан үсгээр бичүүлэн залж төрийн гурван эрдэнийн нэг болгосон хаан хэн бэ? (2 оноо)  
 А. Цогт хунтайж В. Түмдийн Алтан хаан С. Түмэн засагт хаан  
 D. Цахарын Лигдэн хаан E. Автай сайн хаан
21. Цэгийн оронд тохирох өгөгдлийг сонгоно уу. (2 оноо)  
 Сумыг сумын ..... захирч, аливаа хэргийг эрхлэн хариуцна.  
 А. Засаг ноён В. Захирагч С. Мэйрэн  
 D. Залан E. Занги
22. Монголчуудын зүгээс Манж чин улсад залгуулж байсан албанаас хамгийн хүнд хүчир алба юу байв? (2 оноо)  
 А. Цэргийн В. Харуулын С. Өртөөний  
 D. Сүрэг адуулах E. Албан тарианы
23. Цэгийн оронд тохирох өгөгдлийг сонгоно уу. (2 оноо)  
 Жинжлэгээс Ил хүртэл байрлаж байсан 50 суурь харуулд дан биеэр очиж хаадаг хилийн харуулын албыг ..... гэнэ.  
 А. Гэр харуул В. Дотоод харуул С. Суман харуул  
 D. Суурь харуул E. Цэргийн харуул
24. Цэгийн оронд тохирох өгөгдлийг сонгоно уу. (2 оноо)  
 Манж нар ..... цэргийн хэрэгцээнд зориулан Монголчуудаар тариалангийн алба гүйцэтгүүлдэг байлаа.  
 А. Улиастайд В. Улаангомд С. Ховдод  
 D. Туулын адагт E. Халх гол хавьд
25. Өгөдэй хааны үед бий болж, улмаар улам бүр хөгжсөөр 1949 он хүртэл байсан алба юу вэ? (2 оноо)  
 А. Цэрэг В. Өртөө С. Харуул  
 D. Сүрэг адуулах E. Ангийн үсний

26. Манжийн эрхшээлийн үед Ар Монголд анх хэзээ, хаана албаны сургууль байгуулагдсан бэ? (2 оноо)  
 А. 1709 онд Улиастай хотод  
 В. 1760 онд Их хүрээнд  
 С. 1776 онд Ховд хотод  
 D. 1777 онд Сан бэйсийн хүрээнд  
 E. 1802 онд Хар хорум хотод
27. Манжийн эрхшээлийн үед шашны сургуульд юу зааж байсан бэ? (2 оноо)  
 1. Монгол бичиг  
 2. Бурханы сургаал  
 3. Манж бичиг  
 4. Төр ёсны үзэл  
 5. Эрдэм мэдлэгийн салбар ухааны үндэс  
 6. Манжийн хууль цааз  
 7. Ёс суртахуун  
 8. Ардын мэдлэг  
 9. Зан заншил  
 А. 1, 2  
 В. 2, 3  
 С. 2, 7  
 D. 2, 5  
 E. 2, 4
28. Аль нь Манж чин улсын “Шинэ засгийн бодлого”-ын хүрээнд шашны талаар баримталсан бодлого вэ? (2 оноо)  
 А. Шарын шашныг улам бүр дэмжин тэтгэх болсон  
 В. Шарын шашныг дэмжин тэтгэх бодлогоосоо ухарсан  
 С. Улааны шашныг дэмжих бодлого барьсан  
 D. Монголын бөөгийн мөргөлийг сэргээхийг оролдсон  
 E. Христосын шашныг дэмжих бодлого барьсан
29. 1911 оны зун Халхын дөрвөн аймаг, Их шавийн эрх мэдэл бүхий ноёд, лам нар Жавзандамба хутагтад “бат оршил” өргөх үеэр Их хүрээний Эрдэнэ Шанзудбын яаманд хийсэн нууц зөвлөгөөнөөр ямар асуудал хэлэлцсэн бэ?  
 А. Хувьсгал хийх тухай  
 В. Манж, хятадуудыг хөөн гаргах тухай  
 С. Шинэ засгийг бодлогыг хэрхэх тухай  
 D. Орос улсаас тусламж авах тухай  
 E. Зэр зэвсэг цуглуулах тухай
30. 1911 оны зун Орос улсаас тусламж эрсэн төлөөлөгчид ямар бичиг авч явсан бэ? (2 оноо)  
 А. VIII богд Жавзандамба хутагтын бичиг  
 В. Халхын 4 аймгийн хангуудын бичиг  
 С. Эрдэнэ шанзудбын яаманд болсон зөвлөлгөөнөөс гаргасан бичиг  
 D. Богд уулын арын ой дотор болсон зөвлөгөөнөөс гаргасан бичиг  
 E. VIII Богд Жавзандамба хутагт болон Халхын 4 аймгийн хангууд нэр хамтатган өргөсөн бичиг
31. Цэгийн оронд тохирох өгөгдлийг сонгоно уу. Богд хаант Монгол улсын засгийн газрын Дотоод яамны тэргүүн сайдад ..... ыг тохоон томилжээ. (2 оноо)  
 А. Чин ван Ханддорж  
 В. Да лам Цэрэнчимэд  
 С. Түшээ гүн Чагдаржав  
 D. Далай ван Гомбосүрэн  
 E. Эрдэнэ ван Намсрай
32. Цэгийн оронд тохирох өгөгдлийг сонгоно уу. Цаг хугацаа заан тулган шаардаж Сандо амбаныг ..... хөөн гаргаснаар Их хүрээнд Манжийн төрийн ноёрхол унав. (2 оноо)  
 А. 1911.12.29-нд  
 В. 1911.11.30-нд  
 С. 1911.12.01-нд  
 D. 1911.12.4-нд  
 E. 1911.12.5-нд
33. Бүгд ерөнхийлөн захирах яам байгуулагдахаас өмнө тэргүүн сайдын дараагийн сайдын үүргийг ямар яамны сайд гүйцэтгэж байсан бэ?  
 А. Дотоод  
 В. Гадаад  
 С. Сангийн  
 D. Шүүх  
 E. Цэргийн
34. 1915 оны эхээр учир битүүлгээр нас барсан төрийн зүтгэлтэн хэн бэ? (2 оноо)  
 А. Чин ван Ханддорж  
 В. Да лам Цэрэнчимэд  
 С. Сайн ноён хан Намнансүрэн  
 D. Түшээ гүн Чагдаржав  
 E. Шанзудба Бадамдорж
35. Дараах 2 багананд бичигдсэн зүйлсийн хоорондын хамаарлыг тогтооно уу. (2 оноо)  
 а. Богд хааны эрх хэмжээ  
 в. Бүгд ерөнхийлөн захирах яамны эрх хэмжээ  
 с. Улсын хурлын эрх хэмжээ  
 1. Тулгамдсан асуудлыг хэлэлцэх  
 2. Улсын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх  
 3. Дээд албан тушаалтныг томилох, огцруулах  
 4. Улс орныг байнгын төрийн удирдлагаар хангах  
 5. Зөвлөх  
 6. Цол, хэргэм, зэргээр шагнах  
 7. Гадаад улстай байгуулсан гэрээг батлах  
 8. Улстөр, нийгэм, эдийн засгийн шинэтгэлийг удирдах  
 9. Элч төлөөлөгч илгээх  
 10. Улстөр, нийгэм, эдийн засгийн шинэтгэлийн хэрэгжилтэд хяналт тавих  
 11. Яамдын өргөн мэдүүлсэн айлтгал бичгийг хянах, ёсоор болгох  
 12. Бодлого боловсруулах

- А. а - 1, 4, 6, 9, 11; в - 3, 8, 10; с - 2, 5, 7, 12  
 В. а - 2, 4, 6, 9, 12; в - 1, 3, 8, 10; с - 2, 5, 7, 11  
 С. а - 2, 4, 9, 12; в - 1, 3, 10; с - 2, 5, 6, 7, 8, 11  
 D. а - 2, 3, 6, 7, 9, 11; в - 4, 8, 10; с - 1, 5, 12  
 E. а - 2, 4, 6, 9, 11; в - 1, 8, 10; с - 3, 5, 7, 12
36. Хүрээний бүлгэмийн үндэслэгчид хэн бэ? (2 оноо)  
 А. Д.Сүхбаатар, М.Дугаржав, Жамъян В. С.Данзан, Д.Сүхбаатар, Ө.Дэндэв  
 С. Д.Сүхбаатар, С.Данзан, Ө.Дэндэв D. С.Данзан, Ө.Дэндэв, Д.Догсом  
 E. С.Данзан, Д.Сүхбаатар, Галсан
37. Хүрээний ба Консулын бүлгэмийнхэн 1920. 06. 25-нд С.Данзангийн гэрт хамтран хуралдаж гаргасан түүхэн шийдвэр аль нь вэ? (2 оноо)  
 А. Хоёр бүлгэмийг нэгтгэн МАН-ыг байгуулсан  
 В. Ноёдын бүлгэмтэй холбоо тогтоохоор тохирсон  
 С. Ардын журамт цэрэг байгуулахаар шийдсэн  
 D. Үндэсний ардчилсан хувьсгалыг эхлүүлэхээр шийдсэн  
 E. Гадаад Монголын автономит эрхийг сэргээсэн
38. Цэгийн оронд тохирох өгөгдлийг сонгоно уу. ЗОУ-аас тусламж хүсэх төлөөлөгчөөр томилогдсон ардын намын анхны долоод ..... нар багтжээ. (2 оноо)  
 А. Д.Бодоо, Ө.Дэндэв В. Д.Чагдаржав, М.Дугаржав  
 С. С.Данзан, Х.Чойбалсан D. Д.Сүхбаатар, С.Жамъян  
 E. Д.Догсом, А.Жигмиддорж
39. Үйл явдлын он цагийн хамаарлыг зөв тогтоо. (2 оноо)  
 1. БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчид, СнЗ империалист Японыг а. 1945.05.09  
 бут цохих үйлст өөрийн хувь нэмрээ оруулах, тусгаар тогтнол,  
 аюулгүй байдлаа хангах үүднээс Японд дайн зарлажээ.  
 2. ЗХУ Ялтын Бага хурлаар хүлээсэн үүргээ биелүүлэн Японд дайн зарлав. б. 1945.08.09  
 3. Фашист Герман буун өгч Европод энх амгалан байдал тогтов. в. 1945.08.10  
 4. Япон үг дуугүй бууж өгөх актад гарын үсэг зурлаа. г. 1945.09.02  
 5. Бүх нийтийн санал хураалт, БНМАУ-ын эрх чөлөө, тусгаар тогтнолын д. 1945.10.20  
 баярын өдөр болж өнгөрчээ.  
 А. 1б, 2в, 3 а, 4г, 5д В. 1б, 2в, 3д, 4а, 5г С. 1б, 2в, 3г, 4д, 5а  
 D. 1в, 2б, 3а, 4г, 5д E. 1д, 2в, 3г, 4б, 5а
40. Халх голын байлдаанд онцгой гавьяа байгуулж, БНМАУ-ын баатар цолоор хэн хэн шагнуулсан бэ? (2 оноо)  
 А. Аюуш, Дандар, П.Чогдон В. Данзанваанчиг, Дандар, Экей  
 С. Дампил, Дандар, Гэлэгбаатар D. Дандар, Экей, Олзвой  
 E. Жанчив, Гэлэгбаатар, Дандар
41. Цэгийн оронд тохирох өгөгдлийг сонгоно уу. Хубилай хааны зарлигаар ..... үсгийг ..... онд..... зохиожээ. (2 оноо)  
 А. Али гали - 1587 - Аюуш гүүш В. Дөрвөлжин - 1269 - Чойжи-Одсэр  
 С. Тод - 1648 - Зая бандид Намхайжамц D. Соёмбо - 1686 - Өндөр гэгээн Занабазар  
 E. Дөрвөлжин - 1269 - Пагва лам
42. Чингис хаан хар усан морин жил буюу 1162 онд Ононы Дэлүүн болдогт төржээ. Чингис хааны төрсөн оныг зууны тоололд шилжүүлнэ үү. (2 оноо)  
 А. XI зуун В. XII зуун С. XI зууны II хагас  
 D. XII зууны II хагас E. XIII зууны II хагас
43. Эцэг, хүү, ач, гучийн холбоотон аль нь вэ? Зөв хариуг сонгоно уу. (2 оноо)  
 А. Чингис, Өгэдэй, Хубилай, Чингим В. Чингис, Тулуй, Хубилай, Чингим  
 С. Чингис, Тулуй, Аригбөх, Чингим D. Тэмүжин, Өгэдэй, Хубилай, Аригбөх  
 E. Тэмүжин, Тулуй, Аригбөх, Хубилай
44. XI зууныг онд шилжүүлвэл хэдээс хэдэн он бэ? Зөв хариултыг сонгоно уу. (2 оноо)  
 А. 1000 -1100 В. 1001 - 1100 С. 1100 - 1200  
 D. 1101- 1200 E. 1100 -1200
45. XX зууны эхэн үед монголчуудын аж амьдрал дорой, алба дарамт хүнд, өвчин эмгэг дэлгэрснээс монгол хүний дундаж наслалт дөнгөж 40 хүрч байв. Эдүгээ нийгмийн хөгжлийн үр дүнд ард түмний амьдрал дээшилж хүн амын дундаж наслалт 65 болсон гэж үзвэл, дурдсан хугацаанд монгол хүний дундаж наслалт хэдэн хувиар өссөн бэ? Зөв хариултыг сонгоно уу. (2 оноо)  
 А. 60 В. 61,5 С. 62 D. 62,5 E. 63

46. Өгөдэй хаан 1228 – 1241 онд төр барьжээ. Өгөдэй хааны төр барьсан оныг зуунд шилжүүлсэн, зөв хариултыг сонгоно уу. (2 оноо)  
А. XII зууны дунд орчим В. XII зууны I хагас С. XIII зууны дунд үед  
D. XIII зууны I хагас E. XIV зууны I хагас
47. Феодалын хөрөнгө хураах кампанит ажлын хүрээнд хуучны түшмэд, ноёд, язгууртан, хутагт хувилгаадын 1560 гаруй өрхөөс 11 сая орчим төгрөгийн хөрөнгө хураасан байна. Хөрөнгө хураахдаа өрхийн ам бүлийн тоог харгалзахгүйгээр 100%-ийн хөрөнгийг үлдээгээд түүнээс илүү гарсан хөрөнгийг хураажээ. Зуун хувь гэдгийг тооцохдоо 30 төгрөгийн хөрөнгийг нэг хувьтай тэнцүүлэн бодсон байна. Тэгвэл нийт хэдэн зуун хувийн хөрөнгө хураасан бэ? Зөв хариултыг сонгоно уу. (2 оноо)  
А. 3666% В. 3666,6% С. 3666,666%  
D. 3666, 66% E. 36666,7%
48. XX зуун хэдээс хэдэн онд үргэлжилдэг вэ? Зөв хариултыг сонгоно уу. (2 оноо)  
А. 1800 -1900 В. 1801 -1900 С. 1900 - 2001  
D. 1901 - 2000 E. 1900 - 2000
49. Монголтранс түргэн өргөжиж, 1930 онд 50 орчим ачааны машинтай байсан бол 1934 онд 433 машинтай болжээ. Дурдсан хугацаанд Монголтрансын машины тоо хэдэн хувь өссөн бэ? Зөв хариултыг сонгоно уу. (2 оноо)  
А. 566% В. 666% С. 766% D. 866% E. 966%
50. Нэг мянган аль нь вэ? Зөв хариултыг сонгоно уу. (2 оноо)  
А. 1 зуун нь нэг мянган В. 10 зуун нь нэг мянган С. 100 зуун нь нэг мянган  
D. 10 мянган нь нэг мянган E. 100 мянган нь нэг мянган

**ХУВИЛБАР В**

1. Хэдий үед Монгол орны голлох уул нурууд, өндөрлөгт мөсөнд хучигдсан бэ? (2 оноо)  
А. 800 000 – 100 000 жилийн үед В. 100 000 – 40 000 жилийн үед  
С. 40 000 – 15 000 жилийн үед D. 15 000 – 8000 жилийн үед  
E. 800 000 – 15 000 жилийн үед
2. Хэдий үед нум сум зохион бүтээсэн бэ? (2 оноо)  
А. Хуучин чулуун зэвсгийн доод үед В. Хуучин чулуун зэвсгийн дунд үед  
С. Хуучин чулуун зэвсгийн дээд үед D. Дунд чулуун зэвсгийн үед  
E. Шинэ чулуун зэвсгийн үед
3. Гурван чулуу тулгалан босгож дээр нь бөмбөгөр ёроолтой шавар сав суулгасан, тулга, тогооны үүслийг мэдэж болохуйц дурсгал олдсон бэ? (2 оноо)  
А. Тамсагбулагийн суурингаас В. Норовлингийн бууцнаас  
С. Баянзагийн бууцнаас D. Зуухын суурингаас  
E. Рашаан хадны суурингаас
4. Хүннү улсын оршин тогтнож байсан нутаг аль нь вэ? (2 оноо)  
А. Цагаан хэрмээс Байгаль нуур, Солонгосын хойгоос Ил тарвагатай хүртэлх нутагт оршиж байв  
В. Хянганы нуруугаар төвлөрч, Шар мөрнөөс Эргүнэ мөрөн, Дорнодын талаас Ляохэ голын эх хүрч байв  
С. Хангайн нуруугаар төвлөрөн Их элсэн говиос Байгаль нуур, Хянганы нуруунаас Алтайн нуруу хүрч байв  
D. Цагаан хэрмээс Байгаль нуур, Ляохэ голын эхнээс Ил тарвагатай хүртэлх нутагт оршиж байв  
E. Их элсэн говиос Байгаль нуур, Солонгосын хойгоос Хар сайр хүртэлх удам нутагт оршин тогтнож байв
5. Модунь шаньюй улсынхаа аль хэсгийг вангууд томилон захируулдаг байсан бэ? (2 оноо)  
А. Түмтүүдийг В. Мянгатуудыг С. Зүүн гарыг  
D. Зуутуудыг E. Аравтуудыг
6. Аль нь Хүннү улсын цэрэг вэ? (2 оноо)  
А. Хатуу нумаар зэвсэглэсэн хөнгөн морин цэрэг  
В. Даргай нумаар зэвсэглэсэн хөнгөн морин цэрэг  
С. Нум сумаар зэвсэглэсэн хөнгөн морин цэрэг  
D. Төмөр жадаар зэвсэглэсэн хөнгөн морин цэрэг  
E. Хүнд морин цэрэг
7. Аль нь барилга хот байгуулалтын хөгжлөөр эртний улсууд дотроос илүү байв? (2 оноо)  
А. Хүннү В. Сяньби С. Нирун D. Түрэг E. Хятан

8. Аль улс нь бурхны шашныг төрийн шашны хэмжээнд хүртэл дээдэлж, дэлгэрүүлсэн бэ? (2 оноо)  
 А. Хүннү В. Сяньби С. Нирун D. Түрэг E. Уйгур
9. Эргүнэ-гүнд анх очсон овгууд аль нь вэ? (2 оноо)  
 А. Хонгирад, Хиян В. Хиян, Нукуз С. Ихрэс, Нукуз  
 D. Арлут, Хиян E. Урианхай, Хонгирад
10. Лу. Алтан товчид тэмдэглэснээр Тэмүжин хэзээ төрсөн бэ? (2 оноо)  
 А. Хар усан бар жилийн зуны эхэн сарын арван долооны бар цагт  
 B. Хар усан луу жилийн зуны дунд сарын арван тавны луу цагт  
 C. Хар усан морин жилийн зуны тэргүүн сарын арван зургааны морин цагт  
 D. Хар усан нохой жилийн зуны адаг сарын арван есний нохой цагт  
 E. Алтан гахай жилийн намрын дунд сарын арван долооны гахай цагт
11. Аль нь Хамаг Монгол улсын хаадын зөв дараалал вэ? (2 оноо)  
 А. Хабул, Амбагай, Хотула, Есүхэйбаатар В. Хабул, Амбагай, Хотула, Тэмүжин  
 C. Хабул, Амбагай, Хадаан, Есүхэйбаатар D. Хабул, Хотула, Хадаан, Есүхэйбаатар  
 E. Хабул, Амбагай, Хотула, Есүхэйбаатар, Тэмүүжин
12. Их Монгол улсын төрийн гол хууль нь ямар нэртэй байсан бэ? (2 оноо)  
 А. Их цааз В. Их засаг С. Үндсэн хууль D. Цааз хууль E. Бага цааз
13. Чингис хаан хэн хэнийг дархан болгосон бэ? (2 оноо)  
 А. Боорчи, Борохул, Зэв, Зэлмэ В. Борохул, Зэв, Сүбээдэй, Зэлмэ  
 C. Зэв, Сүбээдэй, Зэлмэ, Чулуун D. Борохул, Зэлмэ, Боорчи, Сорхон шар  
 E. Зэлмэ, Зэв, Сүбээдэй, Сорхон шар
14. Дараах он цаг болон үйл явдлын хамаарлыг тогтооно уу. (2 оноо)  
 1. 1215 он а. Чингис хаан шархны халуунаар таалал төгсчээ  
 2. 1227 оны 8 сар в. Чингис хаан цэргээ аван эх нутагтаа буцаж иржээ  
 3. 1218 он с. Өгэдэй хаан Чингис хааны гэрээсийг биелүүлж, Алтан улсыг бүрмөсөн  
 эзлэн авчээ  
 4. 1235 он d. Чингис хаан Хорезмын шахад дахин элч илгээн, буруугаа хүлээхийг  
 шаардав. Хорезмын шах элч нараас нь хоёрыг нь алж, нэгийг нь  
 доромжлон буцаажээ  
 5. 1225 оны эх e. Нийслэл Жүндү хот болон зарим чухал газрыг эзлэв  
 А. 1а, 2е, 3а, 4d, 5а В. 1в, 2d, 3в, 4е, 5с С. 1с, 2с, 3d, 4а, 5d  
 D. 1d, 2в, 3с, 4в, 5е E. 1е, 2а, 3d, 4с, 5в
15. Цэгийн оронд дараах өгөгдлүүдээс тохирохыг нь сонгоно уу. (2 оноо)  
 Зургаан түмэн монголын зүүн түмэнд ..... нар багтаж байв.  
 А. Халх, Ордос, Урианхай В. Урианхай, Түмэд, Цахар  
 C. Цахар, Халх, Урианхай D. Халх, Цахар, Ордос  
 E. Ордос, Түмэд, Урианхай
16. Хэн, хэзээ Төвдийн Содномжамцад “Далай лам” цол олгосон бэ? (2 оноо)  
 А. 1271 онд Хубилай В. 1577 онд Алтан хаан  
 C. 1586 онд Автай сайн хаан D. 1590 онд Түмэн засагт хаан  
 E. 1513 онд Батмөнх даян хан
17. 1617 онд Авга хар уул гэдэг газар нийслэл Очир Цагаан хот байгуулсан хаан хэн бэ? (2 оноо)  
 А. Цогт хунтайж В. Түмдийн Алтан хаан  
 C. Түмэн засагт хаан D. Цахарын Лигдэн хан  
 E. Автай сайн хаан
18. Цэгийн оронд тохирох өгөгдлийг сонгоно уу.  
 Манжийн Энх-Амгалан хаан .....чуулганаар Халх Монголыг Манж чин  
 улсын харъяанд орсныг албан ёсоор тунхаглан зарлав. (2 оноо)  
 А. 1686 онд Заг Байдрагийн Хүрэн бэлчирийн чуулганаар  
 B. 1640 онд Тарвагатайн Улаан бураагийн чуулганаар  
 C. 1727 онд Буурын чуулганаар  
 D. 1688 онд Ар элстэйн чуулганаар  
 E. 1691 онд Долнуурын чуулганаар
19. Цэгийн оронд тохирох өгөгдлийг сонгоно уу.  
 Хошууг хошууны..... толгойлж, тухайн хошууны аливаа хэргийг эрхлэн хариуцна. (2 оноо)  
 А. Засаг ноён В. Захирагч С. Мэйрэн  
 D. Залан E. Занги

20. Цэгийн оронд тохирох өгөгдлийг сонгоно уу.  
Манжийн элч, түшмэд, албан бичиг, зэргийг яаралтай нэвтрүүлэн хүргэх зориулалттай цэрэгжүүлсэн морин өртөөг ..... гэдэг байв. (2 оноо)  
А. Цэрэгжүүлсэн өртөө В. Морин өртөө С. Буухиа өртөө  
D. Суман өртөө E. Суурь өртөө
21. Цэгийн оронд тохирох өгөгдлийг сонгоно уу.  
Жинжлэгээс Манжуур хүртэл байрлах 59 харуулд гэр оронтойгоо очиж гүйцэтгэдэг харуулын албыг ..... гэнэ. (2 оноо)  
А. Гэр харуул В. Дотоод харуул С. Суман харуул  
D. Суурь харуул E. Цэргийн харуул
22. XVII зууны сүүлчээс XIX зуун хүртэл Манжийн төрөөс Хятад худалдаачид иргэдийг Монголд бөөнөөр нь оруулахгүй, хязгаарласан бодлого явуулжээ. Үүний шалтгаан юу байв? (2 оноо)  
1. Монголчуудыг холбоотон, түшиг болгох  
2. Цэрэг харуулын хэрэгт ашиглах  
3. Монголын эдийн засаг нь доройтохоос болгоомжлох  
4. Монголчуудаас эсэргүүцэл тэмцэл гарахаас болгоомжлох  
5. Монгол орныг улс төр, эдийн засгийн түшиц газар байлгах сонирхол  
А. 2, 4, 5 В. 1, 5 С. 1, 2, 5 D. 1, 3, 5 E. 1, 2, 3, 4, 5
23. Монголын түүхийн бидэнд мэдэгдэж байгаа анхны түүх бичлэгийн бүтээл юу вэ? (2 оноо)  
А. Монголын нууц товчоо В. Алтан товч С. Судрын чуулган  
D. Чингисийн чулууны бичиг E. Их засаг хууль
24. Ховдод 1776 онд байгуулагдсан Манж, Монгол бичиг зааж сургах сургуульд аль хошуудаас, хэдэн хүүхэд гарган сургасан бэ? (2 оноо)  
А. Баяд, Дөрвөдөөс 30 хүүхэд В. Урианхай, Торгуудаас 20 хүүхэд  
С. Өөлд, Мянгадаас 20 хүүхэд D. Захчин, Дөрвөдөөс 15 хүүхэд  
E. Өөлд, Захчинаас 17 хүүхэд
25. Аль аль нь Манж чин улс “Шинэ засгийн бодлого”-ын хүрээнд шашны талаар авсан арга хэмжээ вэ? (2 оноо)  
1. Лам нарыг эхнэр авахыг зөвшөөрсөн. 2. Лам нарыг цэргийн албанд татсан.  
3. Лам нарыг хар болохыг шаардах болсон. 4. Лам нараас татвар авах болсон.  
5. Шавь нараас татвар авах болсон.  
А. 1, 3, 5 В. 2, 3, 4 С. 2, 4, 5 D. 1, 4, 5 E. 1, 2, 3
26. 1911 оны зун Халхын дөрвөн аймаг, Их шавийн эрх мэдэл бүхий ноёд, лам нар Жавзандамба хутагтад “бат оршил” өргөх үеэр Их хүрээний Эрдэнэ Шанзудбын яаманд хийж байсан зөвлөлгөөнөө яагаад Богд уулын арын ой дотор үргэлжлүүлэх болсон бэ? (2 оноо)  
А. Эрдэнэ Шанзудбын яам хөл хөдөлгөөнтэй байсан тул  
В. Эрдэнэ Шанзудбаас болгоомжилж  
С. Манж амбангаас болгоомжилж  
D. Хоорондоо санал зөрөлдсөний улмаас  
E. Тав тухтай ярилцахын тулд
27. 1911 оны зун тусламж эрж очсон Монголын төлөөлөгчдөд Орос улсын эрх баригчид ямар хариу өгсөн бэ?  
А. Орос улс Монголын Чин улсаас тусгаарлах тэмцлийг бүрэн дэмжинэ.  
В. Монгол улс Чин улсаас тусгаарлах цаг хэдийн болсон.  
С. Монгол одоо Чин улсаас бүрэн тусгаарлах бололцоогүй.  
D. Монгол одоо Чин улсаас бүрэн тусгаарлах бололцоотой.  
E. Орос улс Монголын Чин улсаас тусгаарлах тэмцлийг дэмжих боломжгүй.
28. Цэгийн оронд тохирох өгөгдлийг сонгоно уу. Богд хаант Монгол улсын засгийн газрын Гадаад яамны тэргүүн сайдад .....-ыг тохоон томилжээ. (2 оноо)  
А. Чин ван Ханддорж В. Да лам Цэрэнчимэд С. Түшээ гүн Чагдаржав  
D. Далай ван Гомбосүрэн E. Эрдэнэ ван Намсрай
29. Цэгийн оронд тохирох өгөгдлийг сонгоно уу.  
Жавзандамба хутагтыг Монгол улсын шашин төрийг хослон барьсан хаанаар өргөмжлөх ёслол ..... Их хүрээнд болжээ. (2 оноо)  
А. 1911.12.29-нд В. 1911.11.29-нд С. 1911.12.01-нд  
D. 1911.12.30-нд E. 1911.12.4-нд
30. Бүгд ерөнхийлөн захирах яам байгуулагдахаас өмнө Ерөнхий сайдын үүргийг ямар яамны сайд гүйцэтгэж байсан бэ? (2 оноо)  
А. Дотоод В. Гадаад С. Сангийн D. Шүүх E. Цэргийн



31. 1911 оны Үндэсний хувьсгалын оюун санааны удирдагч хэн бэ? (2 оноо)  
 А. Чин ван Ханддорж В. Да лам Цэрэнчимэд С. VIII Богд Жавзандамба  
 D. Түшээ гүн Чагдаржав E. Шанзудба Бадамдорж
32. 1913 оны сүүл, 1914 оны эхээр Монгол улсын ерөнхий сайд Т.Намнансүрэн тэргүүтэй төлөөлөгчдөд Орос улс ямар болзол тулгасан бэ? (2 оноо)  
 А. Монгол цэргийг Өвөр Монголоос гэдрэг татах  
 В. Хиагтад болох гурван улсын хэлэлцээрт төлөөлөгчөө оролцуулах  
 С. Нармай Монголын хөдөлгөөнөөс татгалзах  
 D. А, В зөв  
 E. Бүгд зөв
33. Дараах хүмүүсээс хэн нь Консулын бүлгэмийн гишүүн бэ? (2 оноо)  
 А. С.Данзан В. Ө.Дэндэв С. Д.Догсом  
 D. С.Жамъян E. М.Дугаржав
34. Хүрээний ба Консулын бүлгэмийнхэн 1920.06.25-нд С.Данзангийн гэрт хамтран хуралдаж гаргасан түүхэн шийдвэр аль нь вэ? (2 оноо)  
 А. Намын хүмүүсийн дагаж явах тангарагийн бичгийг баталсан  
 В. Ноёдын бүлгэмтэй холбоо тогтоохоор тохирсон  
 С. Ардын журамт цэрэг байгуулахаар шийдсэн  
 D. Үндэсний ардчилсан хувьсгалыг эхлүүлэхээр шийдсэн  
 E. Гадаад Монголын автономит эрхийг сэргээсэн
35. Цэгийн оронд тохирох өгөгдлийг сонгоно уу. ЗОУ-аас тусламж хүсэх төлөөлөгчөөр томилогдсон ардын намын анхны долоод ..... нар багтжээ. (2 оноо)  
 А. С.Данзан, Ө.Дэндэв В. Х.Чойбалсан, М.Дугаржав С. Д.Бодоо, Д.Чагдаржав  
 D. Д.Сүхбаатар, С.Жамъян E. Д.Догсом, А.Жигмиддорж
36. ЗОУ-аас тусламж хүсэхээр Эрхүүд очсон Ардын намын анхны долоо тэнд ажил үүргээ хуваарилж нэг хэсэг нь Зөвлөлт засгийн газрын удирдлагатай уулзаж тусламжийн хэргийг бүтээхээр Омск, Москва явахаар болсон билээ. Хэн хэн энэ ажилд хуваарилагдсан бэ? (2 оноо)  
 А. С.Данзан, Д.Сүхбаатар, Х.Чойбалсан В. Д.Чагдаржав, Д.Сүхбаатар, Х.Чойбалсан  
 С. Д.Лосол, Д.Бодоо, С.Данзан D. С.Данзан, Д.Чагдаржав, Д.Лосол  
 E. Д.Чагдаржав, Х.Чойбалсан, Д.Лосол
37. Үйл явдлын он цагийн хамаарлыг тогтоо. (2 оноо)  
 1. 1920.10.02 а. Д.Сүхбаатар ардын журамт цэргийн анхны хороог байгуулжээ  
 2. 1921.02.04 б. Барон Унгерний захирсан “Азийн морин дивиз” Монголын хилд цөмрөн орж иржээ  
 3. 1921.03.1-3 в. Ардын түр засгийн газар байгуулагдав  
 4. 1921.03.13 г. Барон Унгерн хэд хэдэн удаа гамин цэрэгтэй тулалдсаны эцэст Нийслэл хүрээг эзлэн авчээ  
 5. 1921.02 сар д. МАН-ын Төв Хороог 4 хүнтэй баталж, НТХ-ны даргаар С.Данзанг сонгожээ  
 А. 1а, 2г, 3б, 4д, 5в В. 1а, 2д, 3в, 4г, 5б С. 1б, 2г, 3д, 4в, 5а  
 D. 1а, 2б, 3в, 4г, 5д E. 1б, 2а, 3г, 4в, 5д
38. Алтайн урианхайн Саруул гүний хошууны нутаг, Толбо нуурын бүслэлт хэзээ эхэлж, хэд хоног үргэлжилсэн бэ? (2 оноо)  
 А. 1921 оны 8-р сарын эхээр эхэлж, 40 хоног үргэлжилсэн  
 В. 1921 оны 8-р сарын дунд үеэс эхэлж, 42 хоног үргэлжилсэн  
 С. 1921 оны 9-р сарын эхээр эхэлж, 41 хоног үргэлжилсэн  
 D. 1921 оны 9-р сарын дунд үеэс эхэлж, 42 хоног үргэлжилсэн  
 E. 1921 оны 9-р сарын эцсээр эхэлж, 45 хоног үргэлжилсэн
39. Монгол-Оросын хооронд найрамдлын барилдлага байгуулах тухай 13 зүйл бүхий гэрээ бичиг хэзээ, хаана батлагдсан бэ? (2 оноо)  
 А. 1921.11.01, Улаанбаатарт В. 1921.11.02, Эрхүүд С. 1921.11.05, Москвад  
 D. 1921.11.26, Улаан үдэд E. 1921.11.04, Троицко Савск
40. 1945 оны чөлөөлөх дайнд онц гарамгай тулалдаж, зориг баатарлагийн жишээ үзүүлж, БНМАУ-ын баатар цол хүртсэн хүмүүс хэн бэ? (2 оноо)  
 А. Дандар, Дүүдэй, Дампил В. Олзвой, Аюуш, Данзанваанчиг  
 С. Аюуш, Данзанваанчиг, Дүүдэй D. М.Экей, Аюуш, Дампил  
 E. Л.Гэлэгбаатар, Чогдон, Дандар

41. Цэгийн оронд тохирох өгөгдлийг сонгоно уу.  
XIII зууны II хагаст буюу ..... онд ..... үсгийг ..... зохиожээ. (2 оноо)  
А. Али гали - 1587 - Аюуш гүүш В. Дөрвөлжин - 1269 - Чойжи-Одсэр  
С. Тод - 1648 - Зая бандид Намхайжамц D. Соёмбо - 1686 - Өндөр гэгээн Занабазар  
E. Дөрвөлжин - 1269 - Пагва лам
42. 1084 онд Хамаг Монголын нэр түүхэн сурвалжид анх удаа тэмдэглэгджээ. Энэхүү Хамаг Монголын нэр түүхэн сурвалжид тэмдэглэгдсэн оныг зууны тоололд шилжүүлнэ үү. (2 оноо)  
А. X зуун В. XI зуун С. X зууны II хагас  
D. XI зууны II хагас E. XII зууны II хагас
43. Эцэг, хүү, ач, гучийн холбоотон аль нь вэ? Зөв хариуг сонгоно уу. (2 оноо)  
А. Есүхэй, Чингис, Цагаадай, Гүюг В. Есүхэй, Чингис, Өгэдэй, Гүюг  
С. Есүхэй, Чингис, Хубилай, Гүюг D. Есүхэй, Тэмүжин, Аригбөх, Гүюг  
E. Есүхэй, Тэмүжин, Тулуй, Гүюг
44. XII зууныг онд шилжүүлвэл хэдээс хэдэн он бэ? Зөв хариултыг сонгоно уу. (2 оноо)  
А. 1000 -1100 В. 1001 - 1100 С. 1100 - 1200  
D. 1101- 1200 E. 1200 -1300
45. XX зууны эхэн үед Монгол орон хагас сая гаруй хүн амтай байснаас зуу гаруй мянга нь лам нар байжээ. Ойролцоогоор хүн амын хэдэн хувь нь лам нар байсан бэ? (2 оноо)  
А. 10 В. 15 С. 20 D. 25 E. 30
46. Гүюг хаан 1246 – 1248 онд төр барьжээ. Гүюг хааны төр барьсан оныг зуунд шилжүүлсэн, зөв хариултыг сонгоно уу. (2 оноо)  
А. XII зууны дунд үе В. XII зууны I хагас С. XIII зууны дунд үе  
D. XIII зууны I хагас E. XIV зууны I хагас
47. Ардын гэгээрлийн яамнаас мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэхэд анхаарч 1925 онд ЗХУ-д 46, Германд 35, Францад 4 залуу явуулжээ. 1926 онд ЗХУ-д 151, Германд 5 хүн явуулсан бол 1926 онд гадаадад сурахаар явсан хүний тоо өмнөх оныхоос хэдэн хувиар өссөн бэ? Зөв хариултыг сонгоно уу. (2 оноо)  
А. 82,3% В. 82,35% С. 82,352%  
D. 82,354% E. 82,355%
48. XIX зуун хэдээс хэдэн онд үргэлжилдэг вэ? Зөв хариултыг сонгоно уу. (2 оноо)  
А. 1700 -1800 В. 1701 -1800 С. 1800 - 1900  
D. 1801 -1900 E. 1900 - 2000
49. Дундговь аймгийн Дэрэн сумын малчин Манал 14000 төгрөг, Увс аймгийн Өмнөговь сумын малчин Бадам 5450 төгрөг фронтод бэлэглэжээ. Маналын өгсөн бэлэг Бадамынхаас хэдэн хувиар илүү байсан бэ? Зөв хариултыг сонгоно уу. (2 оноо)  
А. 136,88 В. 146,88 С. 156,88  
D. 166,88 E. 176,88
50. 1945 оны чөлөөлөх дайнд онц гарамгай тулалдаж, зориг баатарлагийн жишээ үзүүлж, БНМАУ-ын баатар цол хүртсэн хүмүүс хэн бэ? (2 оноо)  
А. Дандар, Дампил В. Олзвой, Аюуш С. Дампил, Жанчив  
D. Олзвой, Л.Гэлэгбаатар E. Л.Гэлэгбаатар, Чогдон

**ХУВИЛБАР С**

1. Хэдий үед хэрэглэж байсан зэвсгийг хуучин чулуун зэвсэг гэдэг вэ? (2 оноо)  
А. 800 000 - 100 000 жилийн үед В. 100 000 - 40 000 жилийн үед  
С. 40 000 - 15 000 жилийн үед D. 15 000 - 8000 жилийн үед  
E. 800 000 - 15 000 жилийн үед
2. Барагцаагаар хэдий үед Монгол нутагт амьдрагсад мал аж ахуйтай болсон бэ? (2 оноо)  
А. Хуучин чулуун зэвсгийн үед В. Дунд чулуун зэвсгийн үед  
С. Шинэ чулуун зэвсгийн үед D. Эцгийн эрхт овгийн үед  
E. 12 000 жилийн тэртээгээс
3. Хаанаас 12 км урт, 8 км өргөн талбай бүхий чулуун зэвсгийн дархны газар илэрсэн бэ? (2 оноо)  
А. Арц богд В. Баянзаг С. Рашаан хад  
D. Тамсагбулаг E. Цагаан агуй
4. Аль нь Сяньби нарын уугуул нутаг вэ? (2 оноо)  
А. Цагаан хэрмээс Байгаль нуур, Солонгосын хойгоос Ил тарвагатай хүртэлх нутагт оршиж байв  
В. Ордосоос Байгаль нуур өнгөрч, Алтайн нуруунаас Дорнодын тал хүрч байв

- С. Хангайн нуруугаар төвлөрөн Их элсэн говиос Байгаль нуур, Хянганы нуруунаас Алтайн нуруу хүрч байв  
 D. Хянганы нуруугаар төвлөрч, Шар мөрнөөс Эргүнэ мөрөн, Дорнодын талаас Ляохэ голын эх хүрч байв  
 E. Их элсэн говиос Байгаль нуур, Солонгосын хойгоос Хар сайр хүртэлх уудам нутагт оршин тогтнож байв
5. Модунь шаньюй улсынхаа аль хэсгийг вангууд томилон захируулдаг байсан бэ? (2 оноо)  
 А. Түмтүүдийг В. Мянгатуудыг С. Баруун гарыг  
 D. Зуутуудыг E. Аравтуудыг
6. Хүннүчүүд нас барагсдаа хэрхэн оршуулдаг байсан бэ? (2 оноо)  
 А. Чулуун хашлагатай бунханд, ихэвчлэн ил тавьж, мал дагалдуулан  
 B. Шороон хашлагатай бунханд, эсгийнд ороож, морь дагалдуулан  
 C. Дүнзэн хашлагатай бунханд, ихэвчлэн модон австай тавьж, хэрэглэж байсан зүйлсийг нь дагалдуулан  
 D. Төмөр хашлагатай бунханд, арьсанд ороож, ширдэг дагалдуулан  
 E. Шарилыг нь хатааж, тахилын сүм барьж, хөргийг нь залж, дайны олзноос дагалдуулан
7. Аль нь Сяньби улсын цэрэг вэ? (2 оноо)  
 А. Даргай нумаар зэвсэглэсэн хөнгөн морин цэрэг  
 B. Хатуу нумаар зэвсэглэсэн хөнгөн морин цэрэг  
 C. Нум сумаар зэвсэглэсэн хөнгөн морин цэрэг  
 D. Төмөр жадаар зэвсэглэсэн хөнгөн морин цэрэг  
 E. Хүнд морин цэрэг
8. Эртний улсуудаас аль нь газар тариалан арай түлхүү эрхэлдэг байсан бэ? (2 оноо)  
 А. Хүннү В. Сяньби С. Нирун  
 D. Түрэг E. Уйгур
9. Аль улс нь их, бага хоёр бичигтэй байсан бэ? (2 оноо)  
 А. Хүннү В. Сяньби С. Нирун  
 D. Түрэг E. Хятан
10. Аль улс нь Төв Азийн нүүдэлчид ба Хятадын харилцаанд үндсэн эргэлт гаргасан бэ? (2 оноо)  
 А. Хүннү В. Сяньби С. Нирун  
 D. Түрэг E. Уйгур
11. Эргүнэ-гүнд анх очсон овгууд аль нь вэ? (2 оноо)  
 А. Сүлдэс, Нукуз В. Хиян, Нукуз С. Элжигэн, Урианхай  
 D. Баяуд, Хониград E. Нукуз, Урианхай
12. Тэмүжин хар усан морин жилийн зуны тэргүүн сарын арван зургааны морин цагт Онон мөрний Дэлүүн болдог хэмээх газар Есүхэй баатрын Өэлүн хатнаас мэндэлжээ гэж ямар сурвалжид тэмдэглэсэн бэ? (2 оноо)  
 А. Монголын нууц товчоо В. Судрын чуулган  
 C. Лу. Алтан товч D. Плано Карпини Монголчуудын түүх  
 E. Гильом де Рубрук Дорно этгээдэд зорчсон минь
13. Тэмүжинд Чингис хаан цолыг анх хэзээ, хаана, юуны учир өгсөн бэ? (2 оноо)  
 А. 1162 онд Хэрлэний Хөдөө аралд гартаа нөж атгаж төрсөн тул  
 B. 1189 онд Хар зүрхэний Хөх нуурт Хамаг Монголын хаан болсон тул  
 C. 1190 онд Далан Балжудад 13 хүрээний байлдаанд ялсан тул  
 D. 1206 онд Онон мөрний эхэнд Их Монгол улсын хаан болсон тул  
 E. 1196 онд Улзын голд Мэгүжин сүүлтийг бут цохисон тул
14. Алтан улсаас Чингис хаанд юуны учир, ямар цол өгсөн бэ? (2 оноо)  
 А. Алба барьсан тул Чингис цол  
 B. Татаарыг довтолсон тул Чаутхури цол  
 C. Ураг барилдсаны төлөө ван цол  
 D. Буулт хийсэн тул хан цол
15. Дараах 2 багананд бичигдсэн Их Монгол улсын том түмэн хийгээд тэдгээрийн ноёдын хамаарлыг тогтооно уу. (2 оноо)
- |               |            |               |               |
|---------------|------------|---------------|---------------|
| 1. Баруун     | а. Мухулай |               |               |
| 2. Зүүн       | в. Боорчи  |               |               |
| 3. Төв        | с. Наяа    |               |               |
| A. 1а, 2в, 3с |            | B. 1в, 2с, 3а | C. 1с, 2в, 3а |
| D. 1с, 2а, 3в |            | E. 1в, 2а, 3с |               |



27. XIX зууны сүүлч, XX зууны эхэн үед Хятад худалдаачид өртэй хүмүүс өрөө төлж чадахгүй болоход түүнд тусламж болгон 50 лан өгч байжээ. Тэр тусламжийн гол зорилго юу байв? (2 оноо)
- A. Өсгөн үржүүлэх замаар өрөө төлөх боломж олгох  
 B. Өрөө төлүүлж авахын тулд ая тал засах  
 C. Худалдаа хийлгэх  
 D. Сэтгэл санааны дэм өгөх  
 E. Нийт хошуугаар нь өсгөн нэмэгдүүлж төлүүлэх
28. 1911 оны зун Богд уулын арын ой дотор хийсэн нууц зөвлөгөөнд Их хүрээний Эрдэнэ Шанзудбын яаманд хийсэн зөвлөгөөнд оролцсон Халхын дөрвөн аймаг, Их шавийн эрх мэдэл бүхий ноёд, лам нар бүрэн оролцсон уу. (2 оноо)
- A. Бүгдээрээ бүрэн оролцсон  
 B. Хөдөөнөөс ирсэн ноёд, лам нар оролцсон  
 C. Хүрээнд байсан ноёд лам нар оролцсон  
 D. Шинэ засгийн бодлогыг эсэргүүцсэн ноёд лам нар оролцсон  
 E. Манж хятадын дарлалыг эсэргүүцсэн ноёд лам нар оролцсон
29. 1911 оны зун тусламж эрж очсон Монголын төлөөлөгчдөд Орос улсын эрх баригчид юу амласан бэ? (2 оноо)
1. Монголд хийж байгаа шинэтгэлийг болиулах талаар Бээжинд шахалт үзүүлнэ  
 2. Монголын тусгаарлах хөдөлгөөнд зэр зэвсгийн болон мөнгөн тусламж үзүүлнэ  
 3. Пулемёт буу бүхий 2000 казах цэргээр тусална  
 4. Хятадаас монголчуудын эсрэг хийж болзошгүй аллага хядлагаас өмгөөлнө  
 5. Их хүрээн дэх консулын газраа харгалзах цагдаагийн хүчийг цэргээр зузаатгана  
 A. 2, 3, 5      B. 1, 2, 4      C. 2, 3, 4      D. 1, 4, 5      E. 2, 4, 5
30. Цэгийн оронд тохирох өгөгдлийг сонгоно уу.  
 Богд хаант Монгол улсын засгийн газрын Сангийн яамны тэргүүн сайдад .....-ыг тохоон томилжээ. (2 оноо)
- A. Чин ван Ханддорж      B. Да лам Цэрэнчимэд      C. Түшээ гүн Чагдаржав  
 D. Далай ван Гомбосүрэн      E. Эрдэнэ ван Намсрай
31. 1911 оны хувьсгалын үр дүн, түүхэн ач холбогдол юу вэ? (2 оноо)
1. Манж Чин улс мөхөх үндсийг тавьсан  
 2. Ар монголчууд тусгаар тогтнолоо олж, монгол улс сэргэн мандах эхлэл тавигдав  
 3. Манж чин улсын шинэ засгийн бодлогыг таслан зогсоосон  
 4. Монголчуудыг хятадчилан уусгах гэсэн хорт бодлогыг таслан зогсоож, үндэс угсаагаа авран хамгаалав  
 5. Хятадын санаархлыг тасалж чадсан  
 A. 1, 4      B. 2, 5      C. 1, 5      D. 2, 4      E. 4, 5
32. Бүгд ерөнхийлөн захирах яам байгуулагдахаас өмнө Ерөнхий сайдын үүргийг хэн гүйцэтгэж байсан бэ? (2 оноо)
- A. Далай ван Гомбосүрэн      B. Эрдэнэ ван Намсрай      C. Чин ван Ханддорж  
 D. Да лам Цэрэнчимэд      E. Түшээ гүн Чагдаржав
33. Үйл явдал, он цагийн хамаарлыг тогтооно уу. (2 оноо)
1. Халхын хүрээний бүх хэргийг түр ерөнхийлөн шийтгэх газар байгуулагдав      a. 1911.11.30  
 2. Хүрээнд сууж байсан манж амбан Сандо нутаг буцав      в. 1911.12.04  
 3. Ховд хот Манж, Хятад цэргээс чөлөөлөгдөв      с. 1911.12.29  
 4. Улиастай хот Манж, Хятад цэргээс чөлөөлөгдөв      d. 1912.08.07  
 5. Богд хаант Монгол улс байгуулагдав      e. 1912.01.21  
 A. 1a, 2в, 3d, 4с, 5е      B. 1d, 2a, 3в, 4с, 5е      C. 1a, 2в, 3d, 4е, 5с  
 D. 1в, 2a, 3е, 4d, 5с      E. 1d, 2в, 3a, 4с, 5d
34. Цэгийн оронд тохирох өгөгдлийг сонго.  
 1990 оны хувьсгал агуулга, шинж чанараараа ..... хувьсгал байлаа. (2 оноо)
- A. Ардын ардчилсан      B. Үндэсний      C. Хөрөнгөтний ардчилсан  
 D. Үндэсний ардчилсан      E. Ардчилсан
35. Хүрээний ба Консулын бүлгэмийнхэн 1920.06.25-нд С.Данзангийн гэрт хамтран хуралдаж гаргасан түүхэн шийдвэр аль нь вэ? (2 оноо)
- A. ЗОУ-аас тусламж хүсэх төлөөлөгчдийг томилсон  
 B. Ноёдын бүлгэмтэй холбоо тогтоохоор тохирсон  
 C. Ардын журамт цэрэг байгуулахаар шийдсэн  
 D. Үндэсний ардчилсан хувьсгалыг эхлүүлэхээр шийдсэн  
 E. Гадаад Монголын автономит эрхийг сэргээсэн

36. Цэгийн оронд тохирох өгөгдлийг сонгоно уу.  
ЗОУ-аас тусламж хүсэх төлөөлөгчөөр томилогдсон ардын намын анхны долоод ..... нар багтжээ. (2 оноо)  
А. С.Данзан, Х.Чойбалсан, Ө.Дэндэв В. Д.Бодоо, Д.Чагдаржав, М.Дугаржав  
С. С.Жамъян, А.Жигмиддорж, С.Данзан D. Х.Чойбалсан, Магсаржав, Ширэндамдин  
Е. Д.Сүхбаатар, Д.Догсом, Д.Лосол
